



ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК-Н ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

№ 001/001/H01/20260205-001

2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1, Санхүүгийн зохицуулах хорооны Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай тогтоол, Компанийн дүрмийн 7.31.16 дахь заалтад тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Газар шим үйлдвэр ХК нь энгийн хувьцаанд ногдох ногдол ашиг хуваарилах тохиолдол нэг бүрэн хангасан болохыг Хавсралт №1-д зааснаар баталсугай.
2. Газар шим үйлдвэр ХК-ийн нэг (1) ширхэг энгийн хувьцаанд ногдох ашгийн хэмжээг 2,49 төгрөгөөр, нийт хуваарилах ногдол ашгийн дүнг 2,983,301,885 төгрөгөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөр буюу 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашиг төлөх өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тогтоож, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХХК-өөр дамжуулан мөнгөн хөрөнгөөр тараахаар тогтоосугай.
5. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ганбат) –д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ш.АЛТАНБАГАНА